



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 5/24

Модот

**Ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэхь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны жижүүрийн албан тушаалд ажиллаж байсан Бямба-Эрдэнийн Болорчимэгийг өөрийн хүсэлт гаргасны дагуу 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Б.Болорчимэгийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Золбоо Нярав

Нарийн бичиг: О.Жавзмаа Архив, бичиг хэргийн ажилтан

Гишүүн: Д.Ганчимэг Нягтлан бодогч

3. Б.Болорчимэгийн ажлыг хүлээлцэхдээ эд хөрөнгийг картын дагуу хүлээлцэж бусад холбогдох тооцоог хийж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Золбоо)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ